

ДУВА СОХОРЫН ДӨРВӨН ХӨВҮҮН ДОБУН МЭРГЭН АВГАА УРАГ ҮЛ БОЛГОСНЫ УЧИР

Монголын Нууц Товчооны (цаашдаа — МНТ) энэхүү зүйлийг эрдэмтэд янз бүрээр хөрвүүлэн буулгасан байдаг. Тухайлбал, академич Ц. Дамдинсүрэн «Дува сохор ах нь дөрвөн хөвүүнтэй бүлгээ. Дува сохорыг үхсэний хойно түүний дөрвөн хөвүүн, Добу мэргэнийг авга гэж үзэхгүй доромжилж салж нүүгээд дөрвөд овогтон болов» [Дамдинсүрэн 1990: § 11], академич Д. Цэрэнсодном «Дува Сохор ах нь дөрвөн хөвүүнтэй бөлгөө. Тэгж байтал Дува Сохор ах нь үгүй болов. Дува Сохорыг үгүй болсны хойно, дөрвөн хөвүүд нь Добун мэргэн авгаа ураг [төрөлд] үл тооцон доромжилж, хагацаж гэжж нүүв. Дөрвөн овогтон болж Дөрвөд иргэн тэд болов» гэж хөрвүүлсэн [Цэрэнсодном 2000: § 11], эрдэмтэн И. де Рахвилз «*duwa-soqor aqa inu dörben kö'ütü büle'e tedüi atala duwa-soqor aqa inu ügei bol(u)ba duwa-soqor ügei bolu[q] san-u qoyina dörben kö'üt inu dobun-mergen abaqa-yu'an uruq-a ülü bolqan doromjilaju qaqaaju géjü newüba dörben oboqtan bolju dörben irgen tede bolba*» [Rachewilts I. de 1972: § 11] гэж буулгажээ. Эндээс Ц. Дамдинсүрэн, С. А. Козин нарын буулгасан эхийн 11-р зүйлд “ураг үл тооцон”, “ураг” гэдэг ойлголт огт тэмдэглэгдээгүй байдаг их сонирхолтой байна. Гэвч ийнхүү тайлбарлахдаа эрдэм шинжилгээнд хүлээн зөвшөөрөгдсөн И. де Рахвилз, Д. Цэрэнсодном нарын эхийг үндэс болгосон.

Гол дэвшүүлж буй асуудал бол «Дува сохорын дөрвөн хүү Добу мэргэн авгаа ямар учраас ураг эс тоосон бэ?» хэмээх асуудал

болно. Энэ асуудлыг тодруулахын тулд «ураг» хэмээх ойлголтыг чухам ямар агуулгатай, агуулгын цар хүрээ нь ямар болохыг нягтлан тодруулах нь зүйн хэрэг юм.

Ураг хэмээх ойлголтыг нэлээд олон хүн сонирхон судалжээ. Д. Гонгор гуайн бичсэн судалгааны тоймоос [Гонгор 1978: 42] үзэхэд эрдэмтэн Г. И. Рамстедт, Ш. Ивamuра, Ц-Д. Номинханов зэрэг хүмүүс «ураг»-ийг эхийн талын цусан төрлийн холбоо гэж үзсэн байна. Харин доктор Д. Гонгор «Хүмүүс бүлгээрээ өрх гэр болж байхад эх нь тодорхой боловч эцэг нь чухам хэн болох нь мэдэгдэхгүй байв. Ийм үед эхийн талыг баримталсан хүмүүсийн онцгой хүй нэгдэл буй болжээ. Үүнийг эхийн эрхт овог буюу ураг гэж нэрлэж байв» [Гонгор 1978: Стр 43] хэмээгээд ураг нь эхийн удам баримтласан цусан төрлийн холбоот хэсэг бүлэг хүмүүсийн нэгдэл болох нь тодорхой» [Гонгор 1978: стр 43] гэж үзжээ.

“Ураг” гэдэг үгийг хэлзүйн толь бичигт:

1. Худ худгуйн хамаатан; << ураг төрөл, ураг садан; ураг элгэн>> бүх хамаатан цөм <<ураг тогтох>>; хуучирсан а) хоёр этгээд хөвгүүн, охин хоёроо эр, эм болгохоор хэлэлцэж тохирох; б) эхийн умайд үр тогтох; *ураг бололцох* эр, эмийг холбож худ, худгуй болох; *ураг удам* хүн амьтны уг угсаа;
2. Эхийн умайд бий болох үр хээл; ураг унагах, ураг хөндөх дутуу хөнгөжих;
3. Эрэгчний төмс [Цэвэл 1966: стр 596] гэж тайлбарласан бөгөөд эндээс эхийн хэвлий дэхь үр, хүн амьтны уг угсаа гэдгийн онцлон үзэж байна.

Доктор Л. Билэгт ураг төрлийн холбоо нь үр удам тийш доошоо чигтэй гэдгийг онцлохын зэрэгцээ, ураг нь тодорхой оноосон нэргүй байдаг хэмээгээд дундад зууны «Ураг гэдэг нь дундад үеийн монгол хэлэнд нэгэн өвөг дээдсээс гаралтай эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хамт нэрлэж байжээ»[Билэгт 2007: 89] гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг.

Ураг гэдэг үг МНТ-д хэд хэдэн хэлбэрээр гардаг. Тэдгээрийг тохиолдол бүрээр нь нягтлан үзвэл ураг хэмээх үгний утгыг

ойлгож болно. Тухайлбал, «Сайн хүний хөвүүн ажгуу. Язгуур сайт хүний ураг буй за» [МНТ: § 135], «Хадаан, Төдөгөн хоёр ураг үгүй бөлгөө» [МНТ: § 51], «Мэнглиг эцгийн урагт хэн тэнцэх бөлгөө» [МНТ: § 246] гэсэн тохиолдлуудаас нэгэн бие хүний төрсөн үр хүүхдийг «ураг» хэмээн тэмдэглэснийг харж болно.

“Хасарын ураг нэгнээрээ мэдүүл! Алчидайн ураг нэгнээрээ мэдүүл! Отчигины ураг нэгнээрээ мэдүүл! Бэлгүдэйн ураг нэгнээрээ мэдүүл! Тэр ёсоор миний ургийг [мөн] нэгнээр нь мэдүүлж миний зарлигийг үл өөрчлөн эс задалбаас үл эндэн, үл алдана та нар.

Өгээдэйн урагт

Өлөнд хучивч

Үхэр үл идэх

Өөхөнд хучивч

Нохой үл идэхээр төрвөөс миний ургийн [аль] нэгэнд сайн [хөвүүн] үл төрнө гэж үү?» [2000. § 255] гэсэн мэдээнээс ах дүүсийн үр хүүхдүүд нэгэн урагт хамаарах бус өөр өөр шинэ ураг болдог байсныг харж болно. Өөрөөр хэлбэл Тэмүжин, Хасар, Алчидай, Бэлгүдэй, Отчигин нар Есүхэй ураг билээ. Гэвч эдгээр ах дүүсийн үр хүүхдүүд нэгэн ураг бус Тэмүжиний, Хасарын гэх мэт өөр өөр урагт хамаарах юм.

Үүний сацуу МНТ-ы 42-р зүйлд «Belkunotai Belkunot oboqtan boluba. Bukunotai Bukunot oboqtan boluba. Buqu-Qataqi Qatagin oboqtan boluba. Buqutu-Salji Saljuut oboqtan boluba. Bodoncar Borjiqin oboqtan boluba». [Дарваев П.А, Чимитов Г.Г: 1990. § 42]* хэмээн бичсэн байдаг. Энэ нь Добу мэргэний хөвүүд Добу мэргэний урагт хамаарах боловч өөр хоорондоо нэг нэгнийхээ урагт үл хамаарах юм Бэлгүнүт, Бүгүнүд, Хатиган, Салжиуд, Боржигон бол тэдний өөр өөрсдийн овгийн нэр нь юм. Эдгээрээс ураг хэмээх үгний утга, агуулгын цар хүрээ тодрон харагдаж байна. Ураг хэмээх ойлголтын агуулгын хүрээ нь овог, аймгийн хэмжээний бус, зөвхөн нэг л бие хүний үр удмын хүрээнд багтах юм.

Ураглах гэсэн үг тус сурвалжид «эгч Есүй нэрт надаас дээр, хан хүнд зохистой ажээ. Саяхан хадамд урагласан бөлгөө» [Цэрэнсодном 2000: § 155], «Охин хүүхэд төрвөөс эцэг эх нь өөрийн

дураар бүү ураглатугай» [Цэрэнсодном 2000: § 185] хэмээн хоёр удаа гарах бөгөөд хоёул охин хүүхдийг урагт буюу эрд өгснийг «ураглах» хэмээн тэмдэглэсэн байдаг. Үүнээс үзвэл ураг гэж эрэгтэй үр удам гэсэн санааг ерөнхийлөн илтгээд байх шиг. Гэтэл доктор Л. Билэгт «эмэгтэй хүүхдүүд нөхөрт гарахын өмнө өөрийн ургийн гишүүн байсныг» баримтаар баталсан. Гэвч эмэгтэйчүүд өөр ургийн эрэгтэйтэй гэр бүл болно. Түүний хүүхдүүд нь эцгийн урагтаа харьяалагддаг учир эмэгтэй шугамаар ураг салаалах боломжгүй юм. Тиймээс ургийг нэг эцгээс гаралтай эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг нэрлэх бөгөөд ураг дотроо эрэгтэй шугамаа дагаж салбар олон урагт хуваагддаг байсан гэж үзэж болох юм.

МНТ-д олон гарч буй “*uruq-un uruq-a gürtelē*” /ургийн ураг хүртэл/ хэмээх өгүүлэмжүүд урдаа хэн нэгэн хүний нэрийг авсан байдгаас үзвэл энэ өгүүлэмж нь нэг л хүний үр удам, удмын удам, үрийн үр гэсэн санааг илэрхийлж буй нь тодорхой байдаг. Тухайлбал: «Моно койина мину урук бидан-у оро са’ужу энэ мэтү тус киксэн төрү сэткижү мину үгэ бусу үлү болкан урук-ун урук-а күртэлэ Ибага-йин оро бү тасултукан кэ’эн жарлик болба» [МНТ: § 208], «Гэвүбэр са’ури дэ’эрэ са’ужу Мукали-йин урук-ун урук-а күртэлэ күр иргэн-ү күй-онг болтугаи кэ’эн күй-онг нэрэ өкба» [МНТ: § 206] гэх зэргийг дурдаж болно.

МНТ-д 11-р зүйлд дурдагдсаны адил уг сурвалжийн 23-р зүйлд “ураг үл тоон” гардаг боловч үүссэн нөхцөл байдлын хувьд арай өөр түвшинд байх шиг. Дарваев П.А, Чимитов Г.Г нарын Монгол бичгийн галигт «*Eke-yüen Alan-qoa ukai boluqsan-no qoina aqa-nar deu-ner tabuula adusun idee-ben qibiyaldurun, Belkuno-tai, Bukunotai, Buqa-Qadaqi, Buqatu-Salji dorbeule abulcaba. Bodoncar-a-munqaq, budawu biyu, keen, uruq-a ulu toan, qubi ese okba*». [Дарваев, Чимитов: 1990. § 23] Үүнд гарч буй санаа нь Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха хатаги, Бухату Салжи, Бодончар мунхаг болбоос Добу мэргэний хөвүүд бөгөөд түүний шууд урагт багтана. Гэвч Алун-гуа эх үгүй болсны хойны Бодончар мунхагийг бядуу хэмээн дөрвөн ах эцгийн урагтаа үл тоон, түүнд хувь эс хүртээсэн байна. МНТ-ы 24-р зүйлд «*Bodoncar, uruqa ese toagdaju: Ende atara yaun? keeju, qol daaritu, qodoli seultu oroq-sinqula-i unaju: Ukuesu ino*

ukusukai. Aasu ino asuqai! keeju, Onan muren huruu yorciju talbiba. Yorciju, Baljun-aral kurcu, tende ebesun embule ker kiju, tende aba sauba». [Дарваев П.А, Чимитов Г.Г: 1990. § 24] хэмээсэн байдаг бөгөөд урагт үл тоогдсон Бодончар мунхаг ах нараасаа салан одсон тухай гардаг.

Дээр дурдсан зүйлстэй уялдуулан залгамжилсан ургийн талаар дурдах нь зүйн хэрэг юм. Залгамжилсан ураг нь эцгийн ясан талыг баримтлан босоо шугамаар дамжин уламжлагддаг. Үүний хамгийн тод жишээ нь Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ-Чиноос Чингис хаан ураг хүртэл босоо чигт залгамжилсан тэр ураг юм. Ураг бол эцгийн босоо шугамыг дамжин салбарлаж хөгжиж байдаг бөгөөд Бөртэ-Чиноос эхлэн ... Дува Сохороор дамжин дөрвөн овогтон үүсэж, Добу мэргэн, Бодончар мунхагаар дамжин Боржигон овог салбарлан улмаар Хабичи баатар... Тумбинай сэцэн, Хабул хаан, Бартан баатар, Есүхэй баатар [МНТ] хэмээн босоо байдлаар дамжин Чингис хаан (Тэмүжин) хүртэл ирсэн байна. Харин ураг хэвтээ чигтээ нэг үеийг хамаарч улмаар ураг үл болдог байсан байна.

Энэ бүхэнд үндэслэн үзвэл МНТ-д «ураг» хэмээх ойлголт агуулгын хувьд овгийн дотор багтах жижиг харъяалал бүхий байсан. Хиад боржигины Есүхэйн ураг Тэмүжин, Хасар, Бэлгүдэй, Отчигин нар болно. Харин Тэмүжиний хөвгүүд болох Зүчи, Цагаадай, Өгэдэй, Тулуй нар Тэмүжиний ураг болно, Хасарын хөвгүүд Хасарын ураг болно. Бэлгүдэйн хөвгүүд Бэлгүдэйн ураг болно. Отчигины ураг Отчигины ураг болно. Ингэснээр Тэмүжин болон түүний дүү нарын хөвүүд хүүхэд өөр хоорондоо ургийн хувьд тус тусын урагтай болно. Улмаар Зүчийн хөвгүүд Зүчийн ураг болно. Цагаадайн хөвгүүд Цагаадайн ураг болно. Өгэдэйн хөвгүүд Өгэдэйн ураг болно. Энэ мэтээр үргэлжлэнэ. Гэхдээ эдгээр бүх ургууд эргээд эцгээрээ дамжин Есүхэйн ураг, Хиад боржигин овогт хамаарагдах билээ. Монголын нууц товчоонд Чингис хаан Үсүн өвгөнийг “ba’arin aqa-yin uruq büle’ei” [Rachewilts I.de 1972: § 216] ‘Баарин ахын ураг болой’ хэмээн хэлж буйгаас ямар ч хүн өөрийн эцгээрээ дамжин дээд өвгийнхөө урагт харъяалагддаг байсныг харж болно.

Энэ бүхнээс сурвалжлан «Дува сохорын дөрвөн хөвгүүн Добу мэргэн авгаа урагт үл болгосон» учрыг тайлбарлавал, Торголжин баяны ураг Добу мэргэн, Дува сохор хоёр юм. Добу мэргэн урагт түүний таван хөвгүүн багтах авч тэдгээр хөвүүд тус тусын ураг болсон бөгөөд тэрхүү ургийн овог нь МНТ-оо тэмдэглэгдэн үлдсэн байна. Харин Дува сохорын ураг түүний дөрвөн хөвгүүн билээ. Дува сохорын дөрвөн хөвүүн дөрвөн овогтон болсон. Тиймээс л Дува сохорын дөрвөн хөвгүүн авга ахаа урагт үл тооцжээ. Энэхүү санааг МНТ-ы 11-р зүйлд илэрхийлсэн бололтой байна.

Ашигласан ном

Билэгт Л. Раннемонгольские племена. Улан-Батор: Цомирлогтов, 2007.

Бира Ш., Даицэдэн Т. Монголын нууц товчоо. Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2009.

Гонгор Д. Халх товчоон. II. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1978.

Дамдинсүрэн Ц. Монголын нууц товчоо. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1990.

Дарваев А. П., Чимитов Г. Г. Сокровенное сказание монголов. Элиста: Калмыцкое книжное издательство, 1990.

Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966.

Цэрэнсодном Д. Монголын нууц товчоон. Улаанбаатар, 2000.

Rachewilts I. de, Index to the Secret History of the Mongols. Bloomington: Brill, 1972.